



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН СОЁЛЫН  
ТӨВИЙН ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 02 сарын 03 өдөр

Дугаар Б/04

Өмнөдэлгэр сум

**Б.Хонгорзулыг ажилд томилох тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэг, 47 дугаар зүйлийн 47.1, 49.1, 49.2 дахь хэсэг, 50.1.5.дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1,6 дугаар хавсралт, 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралт, 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 82 дугаар тогтоолын хавсралтыг тус тус үндэслэн **ТУШААХ** нь:

1.Баярсайханы Хонгорзулыг 2026 оны 02 дүгээр сарын 03-ны өдрөөс ОНСТ-ын ажилтнаар ажиллуулсугай.

2.Б.Хонгорзулын албан тушаалын зэрэглэлийг ТҮСБ-3 буюу 1,414,000 (нэг сая дөрвөн зуун арван дөрвөн мянга) төгрөг, орон нутгийн нэмэгдлийг 40 хувиар тус тус тооцон бодож олгохыг нягтлан бодогч (Б.Гантулга)-д зөвшөөрсүгэй.

3. Албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргийн хүрээнд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг ханган хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг чанд мөрдөж ажиллахыг Б.Хонгорзулд үүрэг болгосугай.

ДАРГА



Т.МӨНХТӨР